

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/186/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/175
танай _____ -ны № _____ -Т

ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Л.АМГАЛАНБАТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэ-Идэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ-Идэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,447.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын нийт 514,689.6 мянган төгрөгийн 26 гүйлгээ мэдээлэхээс нийт 52,122.6 мянган төгрөгийн 5 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Шинэ-Идэр сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, түүнийг 90.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57,061,563.99	57,345,737.08
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,061,563.99	57,345,737.08
354	Хангамжийн материал	57,061,563.99	57,345,737.08
35420	Аж ахуйн материал	44,510,608.95	46,551,726.04
35470	Бусад хангамжийн материал	12,550,955.04	10,794,011.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,490,363,881.33	1,504,811,088.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,490,363,881.33	1,504,811,088.67
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	1,460,524,695.77	1,475,752,569.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,763,895,154.35	1,761,428,342.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-475,442,007.78	-572,338,921.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	197,282,191.00	290,129,242.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-148,649,466.64	-122,196,972.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	107,338,132.00	118,539,164.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-49,635,332.28	-62,623,382.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,274,649.96	20,274,649.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,015,124.84	-16,936,051.41
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	59,476,500.00	59,476,500.00
393	Биет бус хөрөнгө	29,839,185.56	29,058,518.76
39301	Програм хангамж	3,070,000.00	3,070,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-955,999.84	-1,736,666.64
39303	Бусад биет бус хөрөнгө	27,725,185.40	27,725,185.40
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,547,425,445.32	1,562,156,825.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,547,425,445.32	1,562,156,825.75
51	Засгийн газрын хувь оролцоо	1,547,425,445.32	1,562,156,825.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	952,558,599.80	952,558,599.80
51101	Өмч: - төрийн	952,558,599.80	952,558,599.80
51102	- хувийн	00.00	00.00
51103	- хувьцаат	00.00	00.00
512	Хуримтлагдсан үр дүн	272,427,318.26	292,116,168.00
51210	Өмнөх үеийн үр дүн	272,427,318.26	277,384,787.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	14,731,380.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	322,439,527.26	317,482,057.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,547,425,445.32	1,562,156,825.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	584,166,253.0	643,300,883.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,355,366.0	167,628,083.0
120	Нийтлэг татварын бус орлого	182,355,366.0	167,628,083.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	182,355,366.0	167,628,083.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	780,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	182,355,366.0	166,848,083.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,810,887.0	475,672,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,457,987.0	5,530,800.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,315,000.0	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.0	800,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,142,987.0	4,730,800.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	393,352,900.0	470,142,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	393,352,900.0	470,142,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	501,442,186.0	628,569,502.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,442,186.0	628,569,502.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	497,821,454.0	577,518,328.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,140,955.0	264,477,451.0
210101	Үндсэн цалин	195,896,055.0	211,523,651.0
210102	Нэмэгдэл	65,244,900.0	52,953,800.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,797,639.0	33,203,772.0
210201	Тэтгэврийн даатгал	26,037,700.0	23,758,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,452,600.0	1,942,011.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,962,100.0	1,832,242.0
210204	Ажилгүйдлийн даатгал	554,500.0	451,625.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,790,739.0	5,218,994.0

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,378,361.0	38,306,170.0
210301	Гэрэл, цахилгаан	1,378,358.0	1,306,170.0
210302	Түлш, халаалт	32,000,003.0	37,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	33,010,653.0	23,530,190.0
210401	Бичиг хэрэг	2,115,000.0	2,456,500.0
210402	Тээвэр, шатахуун	17,549,003.0	16,633,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,000.0	2,688,290.0
210404	Ном, хэвлэл	263,800.0	252,400.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,544,250.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,238,600.0	1,500,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6,700,000.0
210604	Урсгал засвар	-	6,700,000.0
2107	Томилолт, зочны зардал	-	2,399,000.0
210702	Дотоод албан томилолт	-	2,399,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,660,750.0	12,436,203.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,027,250.0	10,775,200.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.0	550,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.0	500,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,500.0	224,708.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	45,000.0
210807	Газрын төлбөр	450,000.0	341,295.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,833,096.0	196,465,542.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,773,500.0	42,014,666.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,050,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	114,059,596.0	152,400,875.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,620,732.0	51,051,174.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.0	35,075,800.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,693,200.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	30,522,600.0

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.0	860,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,120,732.0	15,975,374.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,120,732.0	15,975,374.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	82,724,067.0	14,731,380.4
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	82,724,067.0	14,731,380.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	401,810,887.00	476,452,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	780,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	780,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	780,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	780,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,810,887.00	475,672,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,457,987.00	5,530,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,315,000.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,142,987.00	4,730,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	393,352,900.00	470,142,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	393,352,900.00	470,142,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	398,354,887.00	476,452,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,354,887.00	476,452,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,734,155.00	425,761,626.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,140,955.00	264,477,451.00
210101	Үндсэн цалин	195,896,055.00	211,523,651.00
210102	Нэмэгдэл	65,244,900.00	52,953,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,797,639.00	33,203,772.00
210201	Тэтгэврийн даатгал	26,037,700.00	23,588,482.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,452,600.00	1,891,129.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,962,100.00	2,012,051.00
210204	Ажилгүйдлийн даатгал	490,500.00	451,625.00

210205	Эрүүл мэндийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,854,739.00	5,260,485.00
210301	Гэрэл, цахилгаан	33,378,358.00	38,306,170.00
210302	Түлш, халаалт	1,378,358.00	1,306,170.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,000,000.00	37,000,000.00
210401	Бичиг хэрэг	26,304,053.00	23,530,190.00
210402	Тээвэр, шатахуун	2,115,000.00	2,456,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,549,003.00	16,633,000.00
210404	Ном, хэвлэл	3,300,000.00	2,688,290.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	263,800.00	252,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,626,250.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,450,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	00.00	6,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	6,700,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	2,399,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	2,399,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,840,250.00	19,199,403.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,206,750.00	17,538,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	133,500.00	224,708.00
210807	Газрын төлбөр	00.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	341,295.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,272,900.00	37,945,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,272,900.00	35,650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	2,295,640.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,620,732.00	50,691,174.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	500,000.00	34,715,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	3,693,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	30,522,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	500,000.00	500,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,120,732.00	15,975,374.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,120,732.00	15,975,374.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,456,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,456,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,456,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,456,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	3,456,000.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-3,456,000.00	00.00
		00.00	00.00

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	924,833,414.40	93,853,460.00	274,797,044.01	1,293,483,918.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	924,833,414.40	93,853,460.00	274,797,044.01	1,293,483,918.41
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-49,889,055.27	-49,889,055.27
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	952,558,599.80	322,439,527.26	272,427,318.26	1,547,425,445.32
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	952,558,599.80	322,439,527.26	272,427,318.26	1,547,425,445.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	4,957,469.31	4,957,469.31
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	952,558,599.80	322,439,527.26	277,384,787.57	1,552,382,914.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-4,957,469.31	00.00	-4,957,469.31
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	14,731,380.43	14,731,380.43
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	952,558,599.80	317,482,057.95	292,116,168.00	1,562,156,825.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	470,142,000.00	454,166,626.00	15,975,374.00	97%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,142,000.00	454,166,626.00	15,975,374.00	97%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,426,200.00	419,450,826.00	15,975,374.00	96%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,185,300.00	264,477,451.00	2,707,849.00	99%
210101	Үндсэн цалин	214,231,500.00	211,523,651.00	2,707,849.00	99%
210102	Нэмэгдэл	52,953,800.00	52,953,800.00	0.00	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,499,100.00	33,203,772.00	295,328.00	99%
210201	Тэтгэврийн даатгал	23,588,482.00	23,588,482.00	0.00	100%
210202	Тэтгэмжийн даатгал	2,180,733.00	1,891,129.00	289,604.00	87%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,012,051.00	2,012,051.00	0.00	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	457,349.00	451,625.00	5,724.00	99%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,260,485.00	5,260,485.00	0.00	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,000,000.00	38,306,170.00	693,830.00	98%
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	1,306,170.00	693,830.00	65%
210302	Түлш, халаалт	37,000,000.00	37,000,000.00	0.00	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	23,055,000.00	22,700,190.00	354,810.00	98%
210401	Бичиг хэрэг	2,200,000.00	2,176,500.00	23,500.00	99%
210402	Тээвэр, шатахуун	16,083,000.00	16,083,000.00	0.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,688,290.00	311,710.00	90%
210404	Ном, хэвлэл	272,000.00	252,400.00	19,600.00	93%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00	0.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,335,500.00	6,200,000.00	11,135,500.00	36%
210604	Урсгал засвар	17,335,500.00	6,200,000.00	11,135,500.00	36%
2107	Томилолт, зочны зардал	2,958,700.00	2,399,000.00	559,700.00	81%
210702	Дотоод албан томилолт	2,958,700.00	2,399,000.00	559,700.00	81%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,392,600.00	16,268,603.00	123,997.00	99%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг	14,607,600.00	14,607,600.00	0.00	100%

	ажил үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	550,000.00	0.00	100%
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	224,708.00	15,292.00	94%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	45,000.00	0.00	100%
210807	Газрын төлбөр	450,000.00	341,295.00	108,705.00	76%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36000000.00	35895640.00	104,360.00	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,500,000.00	35,500,000.00	0.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	395,640.00	104,360.00	79%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34715800.00	34715800.00	0.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,715,800.00	34,715,800.00	0.00	100%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,693,200.00	3,693,200.00	0.00	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,522,600.00	30,522,600.00	0.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	470,142,000.00	454,166,626.00	15,975,374.00	97%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	470,142,000.00	454,166,626.00	15,975,374.00	97%
132001	Орон нутгийн төсвөөс	470,142,000.00	454,166,626.00	15,975,374.00	97%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	0.00	100%
620001	Удирдах ажилтан	07.00	07.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,310,800.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,310,800.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,310,800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	830,000.0
210401	Бичиг хэрэг	280,000.0

210402	Тээвэр, шатахуун	550,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.0
210604	Урсгал засвар	500,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,930,800.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,930,800.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,050,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,310,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,310,800.0
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,580,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,730,800.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Шинэ-Идэр сумын ЗДТГ нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. 2022 онд “Үндсэн хуулиа чандлан баримталж, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдэд хүнд сурталгүй хурдан шуурхай үйлчлэх” гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих
2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
3. Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах
4. Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах, хяналт тавих
5. Төрийн үйлчилгээг ил тод, шуурхай чанартай, хүртээмжтэй болгож цахимжуулах

ЗДТГ-ын дарга нь нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, түүнийг 90.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу Засаг даргын Тамгын газрын дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна. Мөн сумын Төрийн сангийн мэргэжилтэн гүйлгээ тус бүрээр хяналт хийж, санхүүгийн албаны дарга гүйлгээг баталж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,447.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө	57,061.6	57,345.7	284.1
Нийт хөрөнгө	1,490,363.9	1,504,811.1	14,447.2
Өр төлбөр	1,547,425.4	1,562,156.8	14,731.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,547,425.4	1,562,156.8	14,731.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,547,425.4	1,562,156.8	14,731.4

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн байдлын тайланд их хэмжээний өөрчлөлт гараагүй байна..

Тайланд авлага болон өр төлбөрийн тооцоо үүсгэлгүй ажилласан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 457,888.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 12,253.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 470,142.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 470,142.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 15,975.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 454,166.6 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 15,975.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх удирдлага	80101 Үндсэн үйл ажиллагаа	302,641.3	289,669.1	12,972.2	95.7%
2		80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	41,552.9	39,526.7	2,026.2	95.1%
3		80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	27,780.5	27,780.5	0.0	100%
4		82801 Улсын баяр наадмын зардал	3,000.0	3,000.0	0.0	100%
5		80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	3,693.2	3,693.2	0.0	100%
6		80112 Нийтлэг үйлчилгээ	41,124.4	40,147.4	977.0	97.6%
7	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	32,500.0	32,500.0	0.0	100%
8	Байгаль хамгаалах нөхөн сэргээх	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	14,607.6	14,607.6	0.0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шинэ-Идэр сумын ЗДТГ нь 2022 онд нэмэлт санхүүжилтээр мал тооллогын ажлын санхүүжилт 4,730.8 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,580.0 мянган төгрөг, нийт 6,310.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Дээрх санхүүжилтийн орлогыг баталсан удирдамж, зориулалтын дагуу зарцуулалтын эрх нээлгэж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр анхан шатанд хянаж, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/51 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 501,442.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,521.6 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн хянаж үзлээ. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрсэн болно. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын нийт 514,689.6 мянган төгрөгийн 26 гүйлгээ мэдээлэхээс нийт 52,122.6 мянган төгрөгийн 5 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	2	7,225.3	2	7,225.3	100
Нийт дүн	2	7,225.3	2	7,225.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлангийн толилуулгыг илэрхийлэхдээ нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй илэрхийлсэн байсныг аудитын хугацаанд залруулсан болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 52,122.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж дахин давтахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шинэ-Идэр сумын ЗДТГ-ын 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын нийт 514,689.6 мянган төгрөгийн 26 гүйлгээ мэдээлэхээс нийт 52,122.6 мянган төгрөгийн 5 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн			0	0	0	0		
Мэдээлээгүй	5	52,122.6	0	0	0	0	1	52,122.6
Дүн	5	52,122.6	0	0	0	0	1	52,122.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Норм норматив баримтлаагүй								
Дүн								
Нийт дүн	5	52,122.6					1	52,122.6

АУДИТЫГ ТАЙЛАНГ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ТЭГШДЭЛГЭР

Б.ДАВААНЫМ

Л.МАНДАХНАРАН